


БНХАУ –ЫН ШЭНЬЖЭНЬ ХОТ, ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦГОЙ ЧӨЛӨӨТ БҮС



Шэньжэнь хот нь 1978 онд байгуулагдаж өнөөдрийн байдлаар 13 сая хүн оршин суудаг бөгөөд БНХАУ-ын хамгийн эрчимтэй хөгжиж байгаа хот юм.

ядуу хоцрогдмол хязгаарын нэгэн хөдөө аж ахуйн тосгоноос орчин үеийн шинжлэх ухаан инноваци төвлөрсөн томоохон хот болтлоо хөгжиж байна.





Шэньжэнь бол Хятадын нээлттэй эдийн засгийн анхны чөлөөт бүс, хөгжлийн хурдаараа дэлхий нийтийн анхаарлыг татсан нэр нөлөө бүхий хот юм. Шэньжэнь Хятадын Хонконг, эх газрыг холбосон гүүр, тус улсын өндөр технологийн аж үйлдвэр, санхүүгийн үйлчилгээ, гадаад худалдаа, далайн тээвэр, соёлын талаар чухал байр эзэлдэг. Сүүлийн жилүүдэд тус хот улам бүр хурдтай хөгжиж байна



БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2018 оны 10-р сард Шэньжэнь хотод ажиллах үедээ Хятад улс өөрчлөлтийн алхаагаа алгуурлахгүй, нээлттэй байх алхмаа зогсоохгүй хэмээн зарлаж, "Хятад улс дэлхий нийтэд шинэ гайхамшгийг бүтээх болно" гэж хэлжээ.

2019 оны 8-р сард ХКН-ын Төв хороо “Шэньжэнь хотыг Хятадын онцлогтой социализмын хөгжлийн үлгэр жишээ бүс болгон бүтээн байгуулах тухай санал”-ыг албан ёсоор дэвшүүлсэн.

Шэньжэний үлгэр жишээ бүс байгуулж буй нь Хятад улс өндөр гараанаас, өндөр түвшинд, алсын зорилт тавьж өөрчлөлт нээлтийг урагшлуулж буй бодит алхам юм.

ШЭНЬЖЭНЬ ХОТ

Дэлхийн томоохон үйлдвэрлэл үйлчилгээ, ямар ч шинэ салбарын үйлдвэрлэгчийг эндээс олж болно. Гэвч орчноос гадна боловсон хүчин хамгаас чухал. Манай хотод бизнес эрхлэх таатай орчноос гадна шинэ нээлт, шинэ бүтээл, амжилтын төлөө зүрх сэтгэлээ өгсөн шижгэр залуус цугласанд хамаг учир байгаа юм. Бид байнга илүү цагаар ажилладаг. Үүнийгээ хэвийн зүйл гэж боддог. Учир нь бүх залуус ингэж ажилладаг юм



Шэньжэнь хот гадаадад төгсөгчид бизнес эрхлэхэд зориулж төрөл бүрийн шинжлэх ухааны 17, аж үйлдвэрийн 7 парк байгуулсан юм. Хотын захиргааны үр ашигтай үйл ажиллагаа, нээлттэй бодлогын үр дүнд маш олон гадаадад төгсөгчид Шэньжэньд очиж, бизнес эрхэлсэн нь хотын инновацийн хөгжилд тун сайн хөрс болж өгчээ. 2014 онд 365 мянган хятад залуус гадаадад их дээд сургууль төгсөж эх орондоо ирсний дийлэнх нь Бээжин, Шанхай, Гуанжөү, Шэньжэнь зэрэг өндөр хөгжилтэй хот, төв, баруун нутгийн мужуудын төвд ажлын байртай болсон.



Шэньжэнь хот



Хятадын дөрөв дэх том хот болох Huawei-гийн төрөлх хот нь тогтвортой өсөлтийн том жишиг юм. Шэньжэнь хот нь 80-аад оны эхэн үеийн жижиг суурин газраас 13 сая хүн амтай Хятадад технологийн хөгжлийг авчирсан асар том метрополис болж чадсан юм.



Huawei компани нь Шэньжэнь хотын цахилгаан сүлжээний менежмент, Маван чингэлэг боомтын ложистик, 5G-ийг дэмждэг олон улсын нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг хөнгөвчлөхөд хувь нэмэр оруулж байна.



Хотын нэгдүгээр зэрэглэлийн дижитал дэд бүтэц нь бүх оршин суугчдын амьдралын чадварыг дэмжиж илүү ухаалаг, аз жаргалтай амьдрахад тусладаг. Хотын хэмжээнд ногоон байгууламж ихтэй тул энэ нь нь бусад мега хотууд шиг эдсанагдахгүй илүү ногоон бас аюулгүй санагдуулдаг.